


Төрийн албаны зөвлөлийн
2020 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн
309 дүгээр тогтоолын 51 дүгээр хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Хууль тогтоомжийн нэр огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Биеийн тамир, спортын улсын хороо

Үндэсний шигшээ багийн бодлогын
хэрэгжилтийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Спортын сургалт дасгалжуулалтын
төлөвлөлт, дотоод асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг

Ажлын байрны албан ёсны байршил

Ажлын өдөрт 8 цаг

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р
хороо Бага тойруу-55, Спортын төв ордон

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сургалт дасгалжуулалтын төлөвлөлтийг спортын төрлийн холбоодтой хамтран боловсруулах, зөвлөмж хүргэх, хяналт тавих, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Сонгогдсон спортын төрлийн сургалт-дасгалжуулалтын төлөвлөлт, бэлтгэл, тэмцээн уралдааны хуваарь, сургалт дасгалжуулалтын хөтөлбөр, төлөвлөлтийг спортын төрлийн холбоодтой хамтран боловсруулах;
2. Үндэсний шигшээ багийн спортын төрлүүдийн статистик баримтуудыг бүрдүүлэх, мэдээллийн сантай болох;
3. Эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах, санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах;
4. Үндэсний шигшээ багийн сургалт дасгалжуулалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулах хяналт тавих;
5. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Сонгогдсон спортын төрлийг хариуцан ажиллаж, олон улсын тэмцээн уралдааны хуваарийг тухайн холбоодтой хамтран гаргах, боловсруулан гаргасан сургалт дасгалжуулалтын төлөвлөлтийг хянан, батлагдахад бэлэн болгох;	Сургалт дасгалжуулалтын төлөвлөлт урт, дунд, богино хугацааны хэлбэрээр хийгдэж батлагдсан байна.	Г
	2. Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургуулилтын явц, чанарт хяналт тавих, зөвлөгөөг Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээ хариуцсан байгууллагуудтай хамтран шинжлэх ухааны үндэслэлд тулгуурлан өгөх.	Судалгааны үндсэн дээр багийн хэрэгцээнд үндэслэн багаар, бүлгээр, ганцаарчилсан ажиллаж, сургалт хийж, зөвлөгөө өгсөн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Улс, олон улсын тэмцээнүүдэд үндэсний шигшээ багийн тамирчдын оролцож байгаа байдал, үзүүлж буй амжилтад судалгаа хийж, дүгнэлт, санал гаргах;	Багуудын оролцсон гадаад болон дотоод бэлтгэл, олон улсын тэмцээнд оролцсон байдал зэрэгт дүгнэлт, саналыг боловсруулан танилцуулсан байна.	Г



	2.Спортын төрөл тус бүрийн спортын холбоод, Үндэсний шигшээ багийн тамирчид, дасгалжуулагчдын эв нэгдэл, сахилга дэг журмыг бэхжүүлж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах;	Багуудын гадаадад болон дотоодод хийх хамтарсан бэлтгэлийн тоо нэмэгдэж тухайн спортын төрөл өндөр хөгжсөн улстай хамтран ажиллана.	Г
	3.Насанд хүрэгчид, залуучууд, өсвөрийн үндэсний шигшээ багийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллүүдийг нэгтгэн цахим сангийн өгөгдлийг бэлтгэх.	Шигшээ багуудын цахим өгөгдлүүд нэгтгэгдэж бэлэн болсон байна	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Үндэсний шигшээ багуудын оролцох тэмцээний календарчилсан төлөвлөгөө гаргаж батлуулах, гэрээний дагуу оролцсон дотоодын болон гадаадын бэлтгэл, олон улсын тэмцээн, наадамд дүгнэлт гаргах, гэрээний дүгнэлтэд санал оруулах;	Гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэн, оролцсон арга хэмжээнүүдийг тухай бүр хэлэлцэн тайлагнасан байна.	Г
	2.Үндэсний шигшээ багуудын тэмцээн, бэлтгэл цугларалтын төлөвлөлт болон бусад асуудлаар гарсан өргөдөл, гомдол, саналыг хүлээн авч хариу өгөх.	Хариуцсан асуудалтай холбоотой мэдээллийг иргэн, төрийн болон төрийн бус байгууллагуудад цаг алдалгүй түргэн шуурхай хүргэсэн байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Биеийн тамир, спортын тухай хууль, Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого, Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;	Хариуцсан асуудлаар хууль, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг гаргасан байна.	Г
	2.Сонгогдсон спортын төрлүүдтэй холбогдон хийгдэж буй хурал, зөвлөгөөний тэмдэглэл хөтлөх, гарч буй тушаал шийдвэр, албан бичгийн төслийг боловсруулах;	Захиргааны актыг төслийг зохих журмын дагуу үйлдэж шаардлагатай тохиолдолд даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэнэ.	Г



	3.Үндэсний шигшээ багийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг архивын нэгж болгон шилжүүлэх, хяналт тавих.	Архивын баримт бичгийн бүрдэл хангагдсан байна.	Г
5 дугаар зорилтын хүрээнд	1.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	- спорт /1014/; - багш, биеийн тамирын боловсрол /011410/.	
Мэргэшил	Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	Туслах түшмэл болон түүнээс дээш ангиллын албан тушаалд эсхүл мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - сургалт-дасгалжуулалтын чанарт шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх; - нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдвэрийн хувилбарын талаар зөвлөх мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулах; - бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдвэрийн хувилбарын талаар зөвлөх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;



	<ul style="list-style-type: none"> - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх; - өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх; - аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх; - бусад.
Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, хувийн зан төлөв, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, зарчимч, тууштай байх, ажлын цаг ашиглалтын хувьд нэгжийн хамт олныг үлгэрлэх; - багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - нээлттэй, шударга байх; - бусад.
Бусад	<ul style="list-style-type: none"> - шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх; - худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх; - монгол бичгээр уншиж, бичих чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга



Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн газар, хэлтэс;
- Олимпын наадамд бэлтгэх үндэсний хорооны гишүүд
- Төрийн бус байгууллага, төсөл, хөтөлбөрүүдийн ажилтан;
- Иргэн хуулийн этгээд.


V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА


(Гарын үсэг) (Эцэг/Эх/-ийн нэр, өөрийн нэр)

2020 оны 09 дугаар сарын 28-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 20 09 09

Дугаар: 309

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

Шийдвэрийн огноо: 2020. 9. 28

Дугаар: 5/08

(тамга/тэмдэг)

ДАРГА  Ц.ШАРАВЖАМЦ

2020 оны 9 дугаар сарын 28-ний өдөр

